



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мөст сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2024/57/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 99013699 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Бадрал

Утас: 91983443 Цахим хаяг: Badralts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2024.01.30 № 1105
танай 2024.01.24-ны № 04 -Т

МӨСТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГЫН ҮҮРГИЙН ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ж.УЯНГА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мөст сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мөст сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Цалин хөлсийг илүү тооцон олгосон, автомашины хувийн хэрэг хөтлөөгүй, ямар засвар үйлчилгээ хийгдсэн нь тодорхойгүй, эрүүл мэндийн төвийн стандартад заагдаагүй аппарат худалдан авсан, гаднын тээврийн хэрэгсэлд олгосон шатахууны жолоочийн тооцоо бодоогүй, газрын гэрчилгээ, кадастрын зургийн хэмжээ хоорондоо зөрүүтэй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16.5.1-төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; "16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8-д "Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно", Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны MNS 5081:2013 стандарт, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаал, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.7-д "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй, "Тохиолдсон байх", "Иж бүрэн байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2023 оны 04,05,06,07,08 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум,

тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ, оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, төлбөрийн хэмжээ, санхүүжүүлэх төлбөрийн арга, багц, төлбөрийн хэмжээ, тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах зэрэг журмыг шинэчлэн баталсан байна.

Аудитын гол асуудал

Мөст сумын Эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн даатгалын сангаас иргэдэд үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний санхүүжилтээр 764.7 сая төгрөгийг авч, 17.1 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авч авлагаар бүртгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Мөст сумын эрүүл мэндийн төв нь тайлант онд 10 зорилтын хүрээнд 70 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 94.0 хувийн биелэлттэй гэж дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:


X. Болдбаатар
Х.БОЛДБААТАР

ХОЁР.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>137,800,742.55</u>	<u>149,104,543.85</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,764,314.62	22,290,702.55
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	3,764,314.62	22,290,702.55
3121	Төгрөг	3,764,314.62	22,290,702.55
31211	Төрийн сангийн харилцах	3,764,314.62	22,290,702.55
33	АВЛАГА	3,853,219.70	19,013,514.76
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	656,043.46	607,426.52
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	17,130,812.00
335	Бусад авлага	3,197,176.24	1,275,276.24
3351	Байгууллагаас авах авлага	3,197,176.24	1,275,276.24
35	БАРАА МАТЕРИАЛ	130,183,208.23	107,800,326.54
351	Түүхий эд материал	53,807,603.68	31,736,287.19
35130	Эм боох материал	53,807,603.68	31,736,287.19
354	Хангамжийн материал	76,375,604.55	76,064,039.35
35410	Бичиг хэргийн материал	4,861,350.00	606,500.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,360,000.00	3,360,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,800,000.00	5,100,000.00
35460	Хүнсний материал	6,615,315.20	3,959,600.00
35470	Бусад хангамжийн материал	59,738,939.35	63,037,939.35
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>595,842,764.09</u>	<u>814,709,522.38</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	595,842,764.09	814,709,522.38
392	Биет хөрөнгө	585,538,764.09	804,405,522.38
39201	Барилга, байгууламж, орон сууц	513,354,000.00	513,354,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-59,005,847.25	-75,872,994.09
39203	Авто-тээврийн хэрэгсэл	122,651,998.00	194,651,998.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-91,088,166.82	-105,435,332.94
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	188,875,755.83	370,493,766.95
39206	Хуримтлагдсан элэгдэл	-101,299,539.67	-124,039,448.38
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	48,299,406.00	70,711,928.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-36,248,842.00	-39,458,395.16
393	Биет бус хөрөнгө	10,304,000.00	10,304,000.00
39301	Программ хангамж	880,000.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-880,000.00	-880,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	10,304,000.00	10,304,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>733,643,506.64</u>	<u>963,814,066.23</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>6,297,680.90</u>	<u>7,286,625.42</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,297,680.90	7,286,625.42
413	Өглөг	6,297,680.90	7,286,625.42
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,999,173.48	163,300.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,476,962.64	5,105,882.64

Мөст сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

4136	Бусад өглөг	2,821,544.77	2,017,442.77
41361	Байгууллагад төлөх өглөг	2,604,852.00	1,412,550.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	216,692.77	604,892.77
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>727,345,825.74</u>	<u>956,527,440.81</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	727,345,825.74	956,527,440.81
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	176,837,308.00	176,837,308.00
51101	Өмч: - төрийн	176,837,308.00	176,837,308.00
512	Хуримтлагдсан үр дүн	135,560,142.66	364,741,757.73
51210	Өмнөх үеийн үр дүн	135,560,142.66	135,560,142.66
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	229,181,615.07
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	414,948,375.08	414,948,375.08
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>733,643,506.64</u>	<u>963,814,066.23</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	779,749,812.12	1,092,021,690.67
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	45,351,532.12	278,028,140.93
120	Нийтлэг татварын бус орлого	45,351,532.12	278,028,140.93
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	45,351,532.12	278,028,140.93
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	45,351,532.12	278,028,140.93
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	734,398,280.00	813,993,549.74
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	310,000.00	11,085,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	810,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	310,000.00	10,275,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	23,648,070.00	53,609,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	23,648,070.00	21,019,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	710,440,210.00	781,888,749.74
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	710,440,210.00	781,888,749.74
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	686,159,202.54	862,840,075.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	686,159,202.54	862,840,075.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	686,159,202.54	862,835,506.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	418,154,972.88	497,407,159.06
210101	Үндсэн цалин	418,154,972.88	254,790,771.00
210102	Нэмэгдэл	00.00	195,287,860.61
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	5,113,000.00
210104	Урамшуулал	00.00	42,215,527.45
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,132,650.54	62,190,690.21
210201	Тэтгэврийн даатгал	35,531,058.99	43,199,422.41
210202	Тэтгэмжийн даатгал	4,150,398.42	4,658,531.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,320,318.34	3,979,175.11
210204	Ажилгүйдлийн даатгал	830,079.08	941,232.91
210205	Эрүүл мэндийн даатгал	8,300,795.71	9,412,328.74

Мөст сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,266,573.00	18,475,231.07
210301	Гэрэл, цахилгаан	3,586,573.00	4,980,231.07
210302	Түлш, халаалт	13,545,000.00	13,360,000.00
210303	Цэвэр, бохир ус	135,000.00	135,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	61,487,759.75	61,661,000.00
210401	Бичиг хэрэг	4,629,350.00	5,057,600.00
210402	Тээвэр, шатахуун	37,839,830.00	46,715,950.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,026,000.00	3,438,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	952,928.00	684,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	5,765,350.00
210408	Бараа материал ақталсны зардал	15,039,651.75	00.00
2105	Нормативт зардал	82,122,985.92	140,562,231.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	71,867,605.92	123,587,436.30
210502	Хоол, хүнс	10,255,380.00	16,974,795.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,464,700.00	12,512,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,527,200.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	937,500.00	00.00
210604	Урсгал засвар	00.00	12,512,800.00
2107	Томилолт, зочны зардал	1,262,000.00	4,382,000.00
210702	Дотоод албан томилолт	1,262,000.00	4,382,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,925,228.00	511,520.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	632,050.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	304,790.00	108,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	127,420.00	103,620.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	121,240.00	24,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	275,000.00
210807	Газрын төлбөр	24,728.00	00.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	265,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,342,332.45	65,132,874.83
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,828,300.00	7,969,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	42,514,032.45	57,163,774.83
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	4,568.93
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	4,568.93
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	4,568.93
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	93,590,609.58	229,181,615.07
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	93,590,609.58	229,181,615.07

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	176,837,308.00	414,948,375.08	92,163,577.00	683,949,260.08
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-50,194,043.92	-50,194,043.92

C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	176,837,308.00	414,948,375.08	41,969,533.08	633,755,216.16
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	93,590,609.58	93,590,609.58
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	176,837,308.00	414,948,375.08	135,560,142.66	727,345,825.74
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	176,837,308.00	414,948,375.08	135,560,142.66	727,345,825.74
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	176,837,308.00	414,948,375.08	135,560,142.66	727,345,825.74
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	229,181,615.07	229,181,615.07
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	176,837,308.00	414,948,375.08	364,741,757.73	956,527,440.81

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>756,610,280.00</u>	<u>796,862,737.74</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	756,610,280.00	796,862,737.74
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	710,440,210.00	00.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	710,440,210.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	310,000.00	11,085,000.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	810,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	310,000.00	10,275,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	23,648,070.00	21,019,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	23,648,070.00	21,019,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	732,652,210.00	764,757,937.74
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	22,212,000.00	00.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	710,440,210.00	764,757,937.74
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>753,491,590.71</u>	<u>778,336,349.81</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	753,491,590.71	778,336,349.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	753,491,590.71	778,331,780.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	420,095,641.02	497,189,305.81
210101	Үндсэн цалин	241,717,700.00	300,675,202.14
210102	Нэмэгдэл	137,724,442.16	140,624,844.41
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,149,000.00	6,094,000.00
210104	Урамшуулал	32,504,498.86	49,795,259.26
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,847,355.56	64,195,800.00

Мөст сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210201	Тэтгэврийн даатгал	35,364,200.00	43,653,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,033,000.00	5,135,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,245,900.00	4,108,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	715,168.27	1,027,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,489,087.29	10,271,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,821,045.00	18,735,231.07
210301	Гэрэл, цахилгаан	2,196,000.00	4,980,231.07
210302	Түлш, халаалт	13,490,045.00	13,620,000.00
210303	Цэвэр, бохир ус	135,000.00	135,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	58,281,814.00	56,736,242.00
210401	Бичиг хэрэг	4,693,400.00	4,163,352.00
210402	Тээвэр, шатахуун	44,020,586.00	44,216,340.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,951,000.00	3,438,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,282,828.00	2,705,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,334,000.00	2,213,450.00
2105	Нормативт зардал	165,963,607.13	110,770,482.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	146,698,446.74	93,736,542.00
210502	Хоол, хүнс	16,626,060.40	15,048,940.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,639,100.00	1,985,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,446,600.00	7,904,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,019,200.00	1,860,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,677,500.00	00.00
210604	Урсгал засвар	7,749,900.00	6,044,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,262,000.00	4,382,000.00
210702	Дотоод албан томилолт	1,262,000.00	4,382,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,925,228.00	3,915,520.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	632,050.00	3,404,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	304,790.00	108,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	127,420.00	103,620.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,240.00	24,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	275,000.00
210807	Газрын төлбөр	24,728.00	00.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	265,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,848,300.00	14,502,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,848,300.00	14,502,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	4,568.93
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	4,568.93
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	4,568.93
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>3,118,689.29</u>	<u>18,526,387.93</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	3,118,689.29	18,526,387.93
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	645,625.34	3,764,314.62
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,764,314.62	22,290,702.55

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	800,658,500.00	778,331,780.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	800,658,500.00	778,331,780.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	799,658,500.00	778,331,780.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	513,566,600.00	497,189,305.81
210101	Үндсэн цалин	314,948,700.00	300,675,202.14
210102	Нэмэгдэл	157,346,500.00	140,624,844.41
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,656,000.00	6,094,000.00
210104	Урамшуулал	33,615,400.00	49,795,259.26
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,195,800.00	64,195,800.00
210201	Тэтгэврийн даатгал	43,653,200.00	43,653,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,135,700.00	5,135,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,108,500.00	4,108,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,027,100.00	1,027,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,271,300.00	10,271,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,739,800.00	18,735,231.07
210301	Гэрэл, цахилгаан	2,854,800.00	4,980,231.07
210302	Түлш, халаалт	15,750,000.00	13,620,000.00
210303	Цэвэр, бохир ус	135,000.00	135,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	46,036,300.00	56,736,242.00
210401	Бичиг хэрэг	4,124,700.00	4,163,352.00
210402	Тээвэр, шатахуун	34,111,300.00	44,216,340.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,300,300.00	3,438,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,625,300.00	2,705,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,874,700.00	2,213,450.00
2105	Нормативт зардал	105,090,500.00	110,770,482.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	87,853,800.00	93,736,542.00
210502	Хоол, хүнс	15,236,700.00	15,048,940.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.00	1,985,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,044,400.00	7,904,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,000,000.00	1,860,800.00
210604	Урсгал засвар	6,044,400.00	6,044,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,499,700.00	4,382,000.00
210702	Дотоод албан томилолт	4,499,700.00	4,382,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,447,700.00	3,915,520.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,000,000.00	3,404,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	650,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	370,000.00	108,900.00

Мөст сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210804	Тээврийн хэрэгслийн татвар	137,700.00	103,620.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	90,000.00	24,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	300,000.00	275,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	500,000.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	400,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,037,700.00	14,502,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,037,700.00	14,502,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,000,000.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	800,658,414.62	796,858,168.81
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	21,019,800.00	21,015,231.07
132001	Орон нутгийн төсвөөс	21,019,800.00	21,015,231.07
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	764,789,300.00	764,757,937.74
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	764,789,300.00	764,757,937.74
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	14,849,314.62	11,085,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,085,000.00	11,085,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	3,764,314.62	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	3,764,314.62
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	22,290,702.55
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	29.00	29.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	20.00	20.00
620003	Үйлчлэх ажилтан	8.00	8.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	29.00	29.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	21.00	20.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8.00	9.00

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 133,060.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 127,913.2 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулагдаагүй нийт 13,428.1 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 13,428.1 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 3,969.1 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт, 8,280.8 мянган төгрөгийн зөрчилд 1 зөрчил арилгуулах албан шаардлага, 1,451.2 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.1 Төлбөрийн акт

1. Орон нутагт ажилласны нэмэгдлийг 2023 онд сувилагч, лаборант, эм зүйч, жолооч, нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудад зөрүүтэй тооцон 2,155,585 төгрөгийг олгосон нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", заасантай тус тус нийцэхгүй байна.

2. 2023 онд сахилгын шийтгэлтэй 2 ажилтанд сахилгын шийтгэлтэйд тооцох хугацаанд үр дүнгийн урамшуулал олгосон нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.7-д "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй." Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8-д "Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

3.2 Албан шаардлага

1. Эрүүл мэндийн төвийн стандартад заагдаагүй тоног төхөөрөмж худалдан авсан, гаднын тээврийн хэрэгсэлд олгосон шатахууны жолоочийн тооцоо бодоогүй нийт 8,280.8 мянган төгрөгийн зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;" "16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны MNS 5081:2013 стандарт, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 5 дугаар хавсралттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Газартай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Газрын гэрчилгээ, кадастрын зураг тус бүрийн хэмжээ хоорондоо зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.1-т "аж ахуйн бүх ажил, гүйлгээ"; 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага"-ыг заавал бүртгэнэ гэсэнтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Газрын албанд хандаж газрын эзэмшлийг үнэн зөв тогтоолгон бүртгэлд тусгах.

2. Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Автомашинд засвар үйлчилгээ хийж хөрөнгө зарцуулахдаа комиссын дүгнэлт гаргаагүй, автомашинд хувийн хэрэг хөтлөөгүй, ямар засвар үйлчилгээ хийгдсэн нь тодорхойгүй байгаа нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 5 дугаар хавсралтаар баталсан "автомашинны сэлбэг хэрэгслийн эдэлгээний доод хязгаар норм"-той нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Автомашинд агрегат, засвар үйлчилгээг хийхдээ өмч хамгаалах зөвлөлд танилцуулан хэрхэн шийдвэрлэсэн талаар шийдвэрийн үндсэн дээр сэлбэг хэрэгслийг олгох, автомашинд ямар засвар үйлчилгээ хийсэн талаар хувийн хэрэгт тэмдэглэх.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Мөст сумын ЭМТ	Бараа материалын орлого дутуу	1	323.4	1	323.4			1	323.4				
	Бараа материалын зарлага дутуу	1	751.1	1	751.1			1	751.1				
	Үндсэн хөрөнгийн орлого дутуу тусгасан	1	126,303.4	1	126,303.4			1	126,303.4				
	Элэгдэл дутуу бодогдсон	1	535.3	1	535.3			1	535.3				
ДҮН		4	127,913.2	4	127,913.2			4	127,913.2				

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Мөст сумын ЭМТ	Автомашинд засвар үйлчилгээ хийж хөрөнгө зарцуулахдаа комиссын дүгнэлт гаргаагүй, автомашинд хувийн хэрэг хөтлөөгүй, ямар засвар үйлчилгээ хийгдсэн нь тодорхойгүй	1	1,451.2					1	1,451.2		
	Орон нутгийн нэмэгдлийг албан хаагчдад зөрүүтэй, сахилгын шийтгэлтэйд тооцох хугацаа дуусаагүй 2 ажилтанд үр дүнгийн урамшуулал олгосонтой холбоотой	1	3,969.1	1	3,969.1						
	Эрүүл мэндийн төвийн стандартад заагдаагүй аппарат худалдан авсан, гаднын тээврийн хэрэгсэлд олгосон шатахууны жолоочийн тооцоо бодоогүй	1	8,280.0			1	8,280.0				
	Газрын гэрчилгээ, кадастрын зураг тус бүрийн хэмжээ хоорондоо зөрүүтэй	1	0						1	0	
ДҮН		4	13,428.1	1	3,969.1	1	7,275.5	2	1,451.2		

ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1				1		